


GPZ 7000 загварын илрүүлэгч Хөрсний тэнцвэрийг оновчтой тохируулах зөвлөгөө

Алтыг амжилттай эрж хайхад хөрсний тэнцвэрийг оновчтой тохируулах зайлшгүй шаардлагатай байдаг. Үүнийг хийхгүйгээр эрдэсжсэн хөрснөөс гарах хуурамч дохио алтны дохиог дарж болзошгүй. Ихэнх алтны хайгуулчид GPX цуврал гэх зэрэг PI илрүүлэгчид ашигладаг хөрсний тэнцвэрийн процессын талаар мэддэг боловч GPZ 7000 загварын шинэ технологи шинэ арга техник эзэмшсэн байхыг шаарддаг. Энэ нийтлэлд хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглахын тулд хөрсний тэнцвэрийг тохируулах *боловсронгуй* аргын тухай тайлбарлаж, маш их амжилттай илрүүлэх зөвлөгөөг өгнө.

GPZ 7000 загварын илрүүлэгчийн хөрсний тэнцвэрийг хэрхэн тохируулахгүй байх вэ

PI технологид GPX цувралын илрүүлэгчийн хөрсний тэнцвэрийг ашиглах



GPX цувралын илрүүлэгчийн хөрсний тэнцвэрийг тохируулах хамгийн түгээмэл арга бол арван хэдэн сантиметрээс хэдхэн сантиметрийн хооронд тавгийг хэд хэдэн удаа өргөж буулгах үйлдэл байдаг. Тавгийн дээш доош хөдөлгөөн дуунд нөлөөлөхөө больтол эсвэл дуут дохионы өөрчлөлт буурч тогтворжтол хөрсний тэнцвэрийн товчийг удаан дарж энэ үйлдлийг ихэвчлэн хийдэг. Үүний дараа хөрсний

тэнцвэрийг товчноос гараа авч, нэг талаас нөгөө рүү савлуулах замаар объектыг хайж эхэлнэ. Хөрсний тэнцвэрийн хамгийн оновчтой утгыг олохын тулд энэ аргаар хөрсний тэнцвэрийн "нарийн ухааны" зөвхөн нэг чиглэлийг өөрчилдөг.

GPZ 7000 загварын илрүүлэгчийн хөрсний тэнцвэрийг тохируулах үйлдэл PI металл илрүүлэгчийнхээс өөр байдаг болохыг мэдэх нь чухал.

GPZ 7000 загварын илрүүлэгч хөрсний олон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, тавгийг **өөрөөр** аргаар хөдөлгөх замаар хөрсний тэнцвэрийг гараар тохируулах хэрэгтэй байдаг ТХД технологийг ашигладаг.

(ТХД технологийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд Minelab компанийн МСН 24-ийг үзнэ үү.)

GPZ 7000 загвар яагаад өөр юм бэ?

Хөрсний тэнцвэрийг тохируулах үед ТХД технологи яадаг вэ?


GPZ 7000 загварын илрүүлэгчийг асааж, Хурдан мэдрэх товчийг дарсны дараа тавгаар газар дээгүүр хөдөлгөснөөс хэдхэн секундийн дотор илрүүлэгч өөрийгөө тухайн хөрсний нөхцөлд тохируулдаг. Дээр тайлбарласан зөвхөн нэг параметр бус тохируулж буй илрүүлэгчийн хэд хэдэн, өөр үзүүлэлтийг энэ эхний хурдавчилсан тохиргоогоор өөрчилж тохируулдаг. Цааш хайх явцад хөрсний тэнцвэрийн тохируулагч хөрсний тэнцвэрийн мэдээллийг нэлээд хурдан тасралтгүй ажиглах буюу "шинэчлэх" боловч эхний хөрсний тэнцвэрийг тохируулах эхний үйлдлийн үеэр тохируулсан нэмэлт параметруудийг илүү удаан шинэчилж тохируулна. Эдгээр нэмэлт хэмжилт GPZ 7000 загварын илрүүлэгчийн хөрсний тэнцвэрийг хэр сайн тохируулахад мөн хувь нэмэр оруулж, таны илрүүлэх явцад хөрсний нөхцөл өөрчлөгдөхийг ажиглаж байдаг.

Хөрсний тэнцвэрийг оновчтой тохируулахын тулд GPZ 7000 загварын илрүүлэгч тухайн газрын хөрс, ялангуяа хөрсний эрдэсжилтийн өөрчлөлтийн талаар аль болох ӨӨР мэдээлэл шаарддаг.


Тиймээс талбайн зөвхөн нэг цэг дээгүүр тавгийг өргөж буулгах ердийн PI аргыг ашиглаж хөрсний тэнцвэрийг тохируулах нь GPZ 7000 загварын илрүүлэгчийн хөрсний тэнцвэрийг тохируулах хамгийн буруу арга юм. Учир нь энэ аргыг ашиглахад том талбай, хөрсний олон төрлийн эрдэсжилтээс авсан мэдээлэл бус талбайн зөвхөн нэг жижиг хэсгээс авсан мэдээллийг л илрүүлэгчид өгдөг.

GPZ 7000 загварын хөрсний тэнцвэрийг хэрхэн тохируулах вэ

ТХД технологид GPZ 7000 загварын илрүүлэгчийн хөрсний тэнцвэрийг тохируулах аргыг ашиглах



Газрын гадаргуу дээр 2–3 сантиметр буюу хөрсний ханалт эсвэл газрын төрх байдлаас шалтгаалан тавгийн зохистой ажиллах өндөрт ердийн нэг талаас нөгөө рүү хайх хөдөлгөөнөөр тавгаар самнах зуур Хурдан мэдрэх товчийг удаан дарнах нь **асаасны дараа эхэлж** хөрсний тэнцвэрийг тохируулах шилдэг арга юм. Үүний зэрэгцээ эхний 10–12 секундэд ялгаатай талбайг аль болох их хамруулахын тулд энгийн үед явган алхахаас арай хурдан урагш алхана уу.



Самналтаа давхцуулахгүйг хичээж эхний удаа хөрсний тэнцвэрийг тохируулахдаа ялгаатай талбайг аль болох их хамруулна уу.

Ингэж дуусаад Хурдан мэдрэх товчноос гар авах бөгөөд илрүүлэгч илрүүлэх ердийн арга ашиглан хайхад бэлэн болно.

Илрүүлэгчийг чимээгүй болгохын тулд тавгийг өргөж буулгах уламжлалт аргыг ашиглан та илрүүлэгч тэр байршилд хэр сайн хөрсний тэнцвэртэй болсныг хялбар шалгах боломжтой.

Анхаар- Та илрүүлэгчийг анх асаасны дараа тавгаар дээш доош хөдөлгөж, хөрсний тэнцвэр шалгах аргыг ашиглах ёсгүй. Харин зөвхөн хэдэн минут хайж эхэлсний дараа ашиглах нь зүйтэй.

Хэдийгээр ТХД дохиог боловсруулах үйл явц хайх явцад хөрсний тэнцвэрийн тохиргоог тасралтгүй шинэчилдэг боловч хөрсний нөхцөл гэнэт өөрчлөгдөж болох бөгөөд илрүүлэгчийн хөрсний тэнцвэрийг дахин тохируулах хэрэгтэй. (Хурдан мэдрэх товчийг удаан дарж, дээрх самнах аргыг ашиглан).

Эхний хөрсний муу тэнцвэрийг засах

Хэрэв та хэвийн бус (жиш. металл объектой хэт ойр эсвэл ердийн бус хөрс) газар хөрсний тэнцвэрийг эхний удаа тохируулах бол эхний тохируулга алдаатай байж болно. Энэ нь илрүүлж байхад нэмэлт дуут дохио дуугарахад хүргэнэ. Энэ нь удаан шинэчлэх тохируулга ердийн нөхцөлд (анхны хэвийн бус нөхцөлийн оронд) илүү нарийвчлахын тулд илүү урт хугацаа шаарддагтай холбоотой юм.

Тиймээс хэрэв та илрүүлэгчээс санаанд оромгүй түвшинд хөрсний дохио гарч байна гэж бодвол илрүүлэгчийг унтрааж асаагаад, хөрсний тэнцвэрийг дахин тохируулна уу. Энэ удаа унтрааж асаасан учир гол төлөв таны илрүүлэгч зөв тохиргоотой болно.



Хэрэв таны илрүүлэгч санаанд оромгүй түвшинд хөрсний дохио өгсөөр байвал Илрүүлэх хуудсанд буй Хурдан ажиллуулах цэсийг сонгож, дараа нь цэс асуухад Дуу, илрүүлэх тохиргоог шинээр тохируулах гэснийг сонгоно уу. Товч зааварт өгсөн дарааллын дагуу хөрсний тэнцвэрийг дахин тохируулна уу.

Таны GPZ 7000 загварын илрүүлэгч зөв хөрсний тохиргоотой болсныг хэрхэн мэдэх вэ?


Хэрэв танд хөрснөөс гарах дуу чанга сонсогдвол нэг цэгт тавгаар хойш урагш ойролцоогоор 20 секунд хөдөлгөнө үү. Хэрэв дуу байхгүй болбол энэ нь хөрсний чимээ байж болзошгүй болохыг харуулна. Хэрэв та Хурдан мэдрэх товчийг удаан дарж байгаа бол ийм байх илүү магадлалтай.

Хүчин чадлыг бүрэн ашиглах зорилгоор хөрсний тэнцвэрийг тохируулах боловсронгуй арга

Хөрсний тэнцвэрийг тохируулах ажиллагааг сайжруулах зорилгоор нэмэлт мэдээллээр хангахын тулд та электрон "феррит" гэж ихэвчлэн нэрлэдэг төмрийн үртсэн тороид ашиглаж болно. Электроникийн салбарт эдгээр соронзон эд ангийг компьютер, зурагт, гар утсанд өргөн ашигладаг.

Хөрсний тэнцвэрийг нарийн тохируулахад тусалдаг маш хэрэгтэй мэдээллийг феррит өгдөг тул феррит ашиглан хөрсний тэнцвэр тохируулах гэдэг нь хөрс тэнцвэржүүлэх эхний үед бага талбайг хамруулна гэсэн үг.

Хөрсний тэнцвэрийг анх тохируулах үед, мөн цаашид тохируулахдаа энэ мэдээллийг нэмэх хамгийн хялбар арга бол хөрсний тэнцвэрийг тохируулах явцад хөрс, феррит хоёулангаас мэдээлэл авахын тулд ферритыг газрын гадаргууд тавьж, тавгийн ажиллах өндөрт өргөн далайж хэд хэдэн удаа тавгаар самнах юм.




Ферритээр хөрсний тэнцвэрийг тохируулах: Өөр өөр талбайг аль болох их хамрахын зэрэгцээ самналтын шугам ферритын дээгүүр маш олон удаа огтлолцох болно.



ЧУХАЛ: Та хөрсний тэнцвэрийг тохируулж бараг эхлэнгүүтээ тавгаа ферритын дээгүүр явуулна уу.

Хэрэв тавгаар ферритын дээгүүр нэг эсвэл хоёр сантиметрийн өндөртэй самнахад GPZ 7000 загварын илрүүлэгчээс бүдэг "авианаас" чанга дуу гарч байвал хөрсний тэнцвэрийг БУРУУ тохируулсан байна. Хэрэв илрүүлэгч их дуут дохио өгвөл дээрх зааврын дагуу ферритыг ашиглан хөрсний тэнцвэрийг дахин тохируулна уу. Хэрэв үүний дараа ферритээс их дуут дохио гарсаар байвал илрүүлэгчийг унтраагаад асааж, дээр дурдсанаар ферритыг ашиглан хөрсний тэнцвэрийг дахин тохируулна уу.




GPZ 7000 загварын илрүүлэгч Minelab компанийн нэмэлт тоноглол ферритыг (сэлбэгийн №. 3011-0301) Minelab компанийн борлуулагчаас үнэгүй авах боломжтой. Үүнийг хөрсний тэнцвэрийг тохируулах үлгэрчилсэн зааврыг бичсэн хуудастай хамт өгнө.

Ферритээр хөрсний тэнцвэрийг тохируулах

1. Объект байхгүй задгай газрыг олж, ферритыг газрын гадаргууд тавина уу.
 2. GPZ 7000 загварын илрүүлэгчээ асаана уу.
 3. Илрүүлэх хуудсанд Хурдан ажиллуулах гэснийг сонгоно уу.
 4. Дуу, илрүүлэх тохиргоог шинээр тохируулах гэснийг сонгоно уу.
 5. Чимээгүй болгох үйлдлийг гүйцэтгэнэ үү.
 6. Хөрсний тэнцвэрийг тохируулахдаа Хурдан мэдрэх товчийг удаан дарж, дараа нь 8-р зурагт буй хөдөлгөөнөөр, энгийн илрүүлэх өндөрт тавгаар самнаж эхэлнэ үү.
- ЧУХАЛ:** Та хөрсний тэнцвэрийг тохируулж бараг эхлэнгүүтээ тавгаа ферритын дээгүүр явуулна уу.
7. Зурагт харуулснаар тавгаар ферритын дээгүүр самнах бүрдээ аль болох их талбай дээгүүр тавгаар үргэлжлүүлэн 10-12 секунд самнана уу.

АНХААР:

Тавгаар ферритын дээгүүр самнахад дуу чимээгүй, тогтвортой болсны дараа хөрсний тэнцвэрийг тохируулж дуусна.



8. Хурдан мэдрэх товчлуураас гараа авч, илрүүлж эхэлнэ үү.

Техникийн дэлгэрэнгүй мэдээлэл

Өндөр давтамжид (жиш. 6-аас 10-ын хооронд анхны нэвтрэх чадалтай 1–30 МГц) тохирсон төмрийн үртсэн тороидыг сайтар шилж сонгосон. Зөвхөн Minelab компанийн энэ нэмэлт тоноглолыг ашиглах нь зүйтэй. Өөр феррит хөрсний тэнцвэрийн чанарыг үлэмж доройтуулж болзошгүй.



Хэврэг бөгөөд амархан гэмтдэг тул ферритыг унагаахаас болгоомжилно уу!